



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.15 № 05/28 УАГ-САГ/2013/24-СГГА-ТӨУГ

**ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ**

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2012 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчлүүд илэрлээ.

Тус компаний 2006 оноос хойш мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулахаар “Мишээл-Од Аудит” ХХК-тай 2012 оны дүгээр сарын 10-ны өдөр 21,0 сая төгрөгийн өртөгтэй 12 дугаар гэрээг байгуулсан байна. Уг гэрээнд “Мишээл-Од Аудит” ХХК нь 2012 оны 10 дугаар сарын 10-ны дотор Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг бэлэн болгон хүлээлгэн өгөхөөр үүрэг хүлээсэн боловч 2013 оны 3 дугаар сарын 25-ны байдлаар биелүүлээгүй байна. Гэтэл “УБЦТС” ТӨХК нийт төлбөр 21,0 сая төгрөгийг 2012 оны 10 дугаар сарын 4-ний өдөр төлсөн, гэрээний биелэлтийг хангаагүй байгаа нь гэрээний 4:3-д “захиалагч ажил гүйцэтгэх харилцан гэрээ байгуулснаас 3 хоногийн дараа урьдчилгаанд нийт төлбөрийн 60 хувь, гэрээт ажил гүйцэтгэн, дүгнэж хүлээлгэн өгснөөс хойш ажлын 3 хоног дотор үлдсэн 40 хувийг төлнө”, мөн гэрээний 5 зүйлд “гүйцэтгэгч гэрээний үүргээ хангалтгүй буюу дутуу биелүүлсэн гэж үзсэн тохиолдолд захиалагч гэрээг цуцулах эрхтэй болно” гэсэн заалтуудыг зөрсөн, гэрээний үүргээ биелүүлээгүй байхад арга хэмжээ аваагүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих...” гэж заасныг үндэслэн **АКТ ТОГТООХ НЬ:**

1. Гэрээт ажлын хөлс 21,0 сая төгрөгийг “Мишээл Од Аудит” ХХК –иар төлүүлэн “УБЦТС” ТӨХК-ий ХААН банкин дахь 5038008080 дугаар дансанд 2013 оны 4 дүгээр сарын 15-ний дотор төвлөрүүлэх,
2. Тогтоосон актын төлбөрийг барагдуулах ажлыг УБЦТС ТӨХК-ий Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Б.Баясгалан, ахлах нягтлан бодогч У.Байгалмаа нарт хариуцуулав,
3. Актын биелэлтийг гаргаж, 2013 оны 4 дүгээр сарын 30-ний дотор УАГ-т ирүүлэх.

070084

АКТЫГ

ТОГТООСОН:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР



Л.ОДГЭРЭЛ

УХА0122

ДАЛАЙВАН-АУДИТ ХХК-ИЙ

Ц.ЖИГДЭН

ЗӨВШӨӨРСӨН:



УБ ЦТС ТӨХК-ИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.ТӨМӨРХҮҮ

УБ ЦТС ТӨХК-ИЙ САНХҮҮ БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БАЯСГАЛАН

УБ ЦТС ТӨХК-ИЙ АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

У.БАЙГАЛМАА

У.БАЙГАЛМАА